

- ¹³ «Миньзу туаньцзе» 1987 № 4 23-р тал
¹⁴ «Чжунго» 1985 № 12, 4-р тал
¹⁵ «Бэйцзин ревью» 1987.Х.9 № 42, 17-р тал
¹⁶ «Ишьюз энд стадиз» 1986, № 4, 74-р тал (Тайваны сэтгүүл)
¹⁷ «Жэньминь жибао» 1987.VI.29
¹⁸ «Жэньминь жибао» 1987.Х.6
¹⁹ «Чжунгун яньцзю» 1986, № 6, 46-р тал (Тайваны сэтгүүл)
²⁰ «Жэньминь жибао» 1987.VI.29

ТҮҮХ, ОРЧИН ҮЕ

БНМАУ-ЫН НУТАГ БОЛ МОНГОЛ
УГСААТНЫ ӨЛГИЙ МӨН

Н. СЭР-ОДЖАВ

Түүхийн ухааны доктор

БНМАУ-ын нутаг бол нэн эртнээс хүн иргэншин суусан эх нутгийн нэг бөгөөд Төв Азийн эртний соёл иргэншил бүрэлдэн тогтсон томхон төв мөн. Тус нутгийн монгол төстөн уугуул хүн ам нь хожим Монгол үндэстэн бүрэлдэн тогтоход шийдвэрлэх үүрэг гүйцэтгэжээ.

Тус улсад явуулсан археологийн сүүлийн үеийн судалгаанаас үзэхэд манай оронд хүн анх 50000-аас сая орчим жилийн завсраас оршин суух болсон байна. Тэр үеийн хүний хэрэглэн байсан чулуун зэвсэг, багажийн зүйлс Баянхонгор аймгийн Өлзийт сумын нутаг, Уран Хайрхан уул Дундговь аймгийн Ярх уул зэрэг газраас олдсон бөгөөд Уран Хайрхан уулын олдвор нь Бээжин хотоос холгүй орших Чжоукоудянь хэмээх газраас олдсон синанторп хүний үйлдэж байсан зэвсэг багажаас нэлээд ах байж магадгүй бололтой байна¹.

Монгол нутагт сууж байсан хүн хуучин чулуун зэвсгийн доод үеэс орчин үеийн хүний шинж төрхтэй болж чулуунаас гадна ясаар зэвсэг багаж үйлдэн ан агнуурыг амьдрахын гол хэрэгсэл болгохын зэрэгцээ Их гол мөрний саваар нутаглан урлаг, шүтэх бишрэх ойлголттой болж байжээ. Хуучин чулуун зэвсгийн үе гэж нэрлэгдэх тэр үеийн хүний орогнон амьдарч, хана туурганд нь арслан, заан, зэрлэг үхэр, адуу, тэмээн хяруул зэрэг амьтдыг улаан зосоор зурсан сүг зураг бүхий агуйг Ховд аймгийн Манхан сумын нутаг Хойд Цэнхэр ууланд манай археологчид олж судалжээ. Хойд Цэнхэрийн агуйн зураг ур чадварын хувьд Франц, Испанийн нутаг дахь дэлхийд алдаршсан агуйн зургаас дутахааргүй байгаа нь монгол нутагт эрт цагт оршин сууж байгаад соёлын хувьд тухайн бүс нутагтаа нэлээд дээгүүр байсны тэмдэг юм².

Хуучин чулуун зэвсгийн үеийн хүн барагцаалбал арваад мянгаад жилийн тэртээгээс хөгжлийн дараахь шат болох шинэ чулуун зэвсгийн үе (неолит)-д шилжин, чулуун зэвсэг багаж хийх арга барил нарийсан сайжирч хэрэглэх зэвсгийн төрөл нь олширсноос гадна нум сум, шавар ваар сав хийж чаддаг болжээ. Өнгө бүрийн цахиур, хаш, голын элгэн тулуу зэргийг билүүдэх, нүхлэх арга техникийг олж шовхлон үзүүрлэ-

сэн чулуунаас нарийхан нимгэн залтас цуулан авч ясан ишний ховилд хавчуулан ир болгон хэрэглэх, билүүдсэн чулуугаар сүх, ооль хийх болжээ. Монгол орны шинэ чулуун зэвсгийн үеийн багаж зэвсэг бусад орныхоос их л өвөрмөц байдаг тул «Монголын бичил зэвсэг» гэдэг нэр томъёо археологийн утга зохиолд хэрэглэгдэх болжээ. Тэр үеийн хүний бууц, булш Дорнод аймгийн Тамсагбулаг, Булган сумын нутаг Норовлин уулнаас олдсон байна. Бууцнаас хожим нь мал болсон амьтны яс, тариа будаа цайруулах самбар чулуу, будааны хальс наалдсан шавар сав олдсон нь Монгол нутагт мал аж ахуй, газар тариалан бие даан үүссэнийг харуулжээ³

Мөн, энэ үед эгэл жирийн арилжаа солио хийдэг байжээ. Говь нутагт олдох зурчин гаргасан хээ бүхий Тэмээн хяруулын өндөгний хальсаар хийсэн гоёлын зүйлс Сэлэнгэ, Хөвсгөл аймгийн нутгаас олдсон ба тэндхийн чулуугаар говийнхоны хийсэн сүх, боль Өмнөговь аймгийн нутгаас олдсон байна.

Дорнод аймгийн Булган сумын нутаг Норовлин уулын ар нугаас илрүүлэн малтсан өөр нэг булшинд билүүдэн зассан чулуун дээр хүний нүүр гарган урласан онго, ясан ишинд нимгэн чулуун ир суулгаж хийсэн хутга, танан чимэгийн зүйл байсан ба Тамсагбулаг, Норовлингийн булшнаас гарсан хүний толгойн ясанд карнилогийн хэмжилт хийхэд тэр үеийн хүн монголчуудын холын өвөг дээдэс болох Төв Азийн монгол төстэй байсан нь мэдэгдсэн байна.⁴

Шинэ чулуун зэвсгийн дараа дөрвөн мянгаад жилийн орчмоос Монгол оронд хүрэл зэвсгийн үе эхэлсэн бөгөөд энэ үед дөрвөлжин булш, бугын чулуу зэрэг зөвхөн монгол нутагт байдаг хосгүй өвөрмөц дурсгал бий болжээ. Өөр газрын дурсгалтай жишээлэх хувьгүй дөрвөлжин булшинд оршуулсан хүний толгойн дор чулуун дэр тавих, адуу, үхрийн дал, дагалдуулсан байх зэрэг нь Монгол хэлтэн аймагтай холбоотой бөгөөд Монгол язгуурын дунху нарын үлдээсэн дурсгал гэж үзэж байна.⁵ Энэ үед Цагаан хэрэмнээс Байгаль далай хүртэлх Их нутагт монголын нүүдэлч аймгуудын соёл иргэншил бүрэлдэн тогтож, түүний нөлөө тусгал Сибирь, Дундад Ази, Өмнө зүгт Хятад оронд ч гүнзгий нэвтэрч байжээ. Тийнхүү Төв Ази, тухайлбал Монгол нутагт үүсэл нь тавигдсан амьтны гаж дүрст урлаг умар зүгт Өмнө Сибирь, баруунаа Хар далай, өмнө зүгт Ордос хүртэлх эргэн нутагт тархан дэлгэрчээ. Дэлхий дахинд «Ордосын хүрэл» гэж алдаршсан ноцолдон уралцаж байгаа амьтад, үлгэр домгийн араатан шувууны дүрс бүхий товруу, чимэгийн зүйлс нүүдэлч дээр дамжин суурьшил иргэдэд хүрсэн байна. Булшнаас гарсан хүн судлалын материалыг өмнөх шинэ чулуун зэвсгийн үеийнхтэй харьцуулан үзэхэд тэр үеийн хүн орчин үеийн монголчуудтай улам ойр төстэй болсныг гэрчилж байна. Шинэ чулуун зэвсэг, хүрлийн үеэс эх үүсэл бүхий монгол төстөн нүүдэлч аймгууд Ази тивийн төв хэсгийг эзэмшин суух тэр нутаг усаа сахин, цаашдын түүхэн хөгжлийн ээдрээтэй урт замыг туулан өнгөрүүлжээ.

Монголын эртний нүүдэлч аймгуудын тухай археологийн дээрх сурвалжаас гадна бичгийн мэдээ, түүх сударт нэлээд байна.

Хятадын Инь улс (МЭӨ XVI—XI зуун) Чжоу улс (МЭӨ XI—III зууны үеийн эд өлгийн дээрх бичээст элсэн говиос өмнүүр Хятадтай хил залгаж байсан эртний нүүдэлч аймгуудын нэр гарч байгаа ба Сяньби, Жужан, Кидан зэрэг монгол угсааны аймгуудын өвөг дээдэс

болох дунху буюу дорнод ху-гийн тухай хятадын түүх сударт тодорхой бичих болжээ⁶.

Дунхугийн аймгууд анх Хятадтай хил залган өнөөгийн Өвөр Монголын нутагт сууж байгаад хожим Амар мөрөн, Өргөн голын сав нутагт сэлгэн суух болжээ. Тэд Монголын төв хэсэг болох Сэлэнгэ, Онон Хэрлэн, Туулын савд нутаглаж байсан уугуул монгол аймгуудтай нэгдэн Монгол туургатны эдийн засаг, улс төрийн байдлыг бэхжүүлсэн ба улмаар монгол оронд нүүдэлчдийн анхны томхон гүрэн Хүннү улс байгуулагджээ. Хүннү гүрэн тэр үеийн Хятадын Хан, Дундад ба Өвөр Азийн Кушан, Европын Ромын улстай мөр зэрэгцсэн томхон гүрэн байсан бөгөөд Азиас Европ хүрсэн «ард түмний их нүүдэл» гэгчийн эхийг тавьж евразийн олон улс аймгийн хувь заяанд идэвхтэй үүрэг гүйцэтгэжээ.

Хүннү гүрэн хөрш зэргэлдээ Дундад Азийн хот-улсууд, Хятадын Хан улс төдийгүй алс холын Византин зэрэг улстай эдийн засаг, улс төр, соёл, дипломатын өргөн харилцаатай байжээ. Хүннү гүрэн, Хятадын Хан улсын хооронд МЭӨ 198 онд Модун шаньюй, Гао-ди хаан нар найрамдлын анхны гэрээ байгуулсан ба 162 онд хүннүгийн Лаошан шаньюй, Хан улсын Сяавэн-ди хаан нар шинэ гэрээ байгуулж «Хүннү ба Хан хоёр хүчин тэнцүү хөрш зэргэлдээ хоёр улс мөн» гэж харилцан зөвшөөрөлцөөд хоёр улсын хилийг Цагаан хэрмээр зааглан тогтоосон байна⁷. Энэхүү гэрээ Монголын феодалууд Хятадыг бүрэн эзлэн авч Монголын Юан улсыг байгуулах хүртэл мянга гаруй жил Монгол Хятад хоёрын хилийн асуудлыг зохицуулах үндсэн баримт бичиг болсоор байжээ.

Хүннүгийн үеийн хот суурины үлдэгдэл, булш бунхан Төв аймгийн Ноён уул, Архангай аймгийн Хүнүй гол, Хэнтий аймгийн Цэнхэр мандал сумын нутаг зэрэг газраас олон олдсон бөгөөд хүннүгийн нийгэм эдийн засаг, соёлын уламжлалыг түүний дараа Монгол нутагт төвлөрөн тогтсон Сяньби, Жужан зэрэг улс гүрэн цаашид хөгжүүлсэн байна.

МЭ VI-IX зууны үеийн Түрэгийн ба Уйгарын хаант улс БНМАУ ын төв хэсэгт төвлөрөн 400-гаад жил тогтнохдоо хот суурины үлдэц, Орхоны руни ба уйгар, согд бичээст хөшөө дурсгал олныг үлдээснийг монгол түрэг Хэлтэн нүүдэлч олон аймгийн соёлын өв мөн гэж үзэх ёстой. Тэдгээрийн дотроос Архангай аймгийн Хашаат сумын нутаг Хөшөө Цайдамд байгаа Кюль Тэгин жанжин, Билгэ хаан, Төв аймгийн Баянзүрх сумын нутаг Баянцагтын ард байгаа Мэргэн сайд Тоньюкук, Булган аймгийн Сайхан сумын нутаг Могойн шинэ ус хэмээх газар байгаа Моюунчур нарын 1000 гаруй жилийн өмнө босгосон руни, уйгар бичээст гэрэлт хөшөө, дурсгалуудыг жишээ болгон дурдаж болно⁸. Тэдгээр хөшөө, дурсгал нь Төв Азийн нүүдэлчин аймгууд хойч үедээ өвлүүлэн үлдээсэн түүх соёлын хэн ч үгүйсгэж чадахгүй чухал баримт юм.

X зууны эхэнд Алтайгаас Номхон далай, Байгаль далайгаас Шар мөрөн хүртэлх нутгийг эзэмшин захирсан Монгол удмын Кидан гүрэн байгуулагдаж, монгол туургатны нийгэм-эдийн засгийн хөгжилд дэвшилттэй нөлөө үзүүлсэн ба Төв ба Дундад Ази, түүний зах зэргэлдээ улс орны түүхэнд мэдэгдэхүйц ул мөр үлдээжээ⁹.

XI зуунаас монгол аймгууд ханлиг улсууд болон тогтнож байгаад XIII зуунд Чингис хаан тэргүүтэй монголын нэгдсэн улсыг байгуулжээ. Чингис хаан Тангад улсыг дайлаар яваад нас барахад түүний шарилыг БНМАУ-ын нутаг Хэнтийн нурууны Их өтөг гэдэг газар

авчирч оршуулжээ. Чингисийн дараа үед түүний үр сад дорно, өрнө зүгт дайн хийж олон улс гүрний ард иргэдийг хэлмэгдүүлсний дотор Хубилай хаан Хятад улсыг бүрэн эзлэн, Тэнд ноёрхолоо тогтоож 100-аад жил хятадын ард түмнийг туйлын харгисаар дарлан мөлжсөн билээ¹⁰.

XIV—XVI зууны үед Монгол оронд феодалын бутрал болж XVII—XIX зуунд Манжийн ноёрхолд орсон юм. Гэвч Монголын ард түмэн тусгаар тогтнол, заяасан нутаг усаа харийн түрэмгийллээс хамгаалан тэмцсээр байжээ. Тэд XX зууны эхээр Манжийн дарлалыг устган Богд хаант Монгол улсыг байгуулан төр улсаа сэргээсэн юм.

1921 онд Аугаа их Октябрийн социалист хувьсгалын нөлөөгөөр Монгол оронд ардын хувьсгал ялж улмаар БНМАУ-ыг тунхагласан билээ. Өнөөдөр манай ард түмэн өвөг дээдсийнхээ өлгий энэ нутагтаа энх тунх элбэг дэлбэг аж төрж, МАХН-ынхаа удирдлагын дор улс орноо социализмын замаар амжилттай хөгжүүлж байна.

БНМАУ-ын нутаг дахь археологийн дурсгал, мөн бичгийн сурвалжийг лавлаж өнгөрсөн түүхийг эргэн харахад Монголын малчин нүүдэлч аймгууд олон мянган жилийн тэртээгээс өвлөн эрхшсэн энэ өлгий нутгаа түүхэн үеийн турш сахин хамгаалж, өвгөд дээдсийнхээ 2000 гаруй жилийн өмнөөс үүсгэн өгсөн төр улсын уламжлалыг алдалгүй хадгалж, Төв Азийн өндөр соёлыг бүтээлцэн улмаар хүн төрөлхтөний нийт соёл, иргэншлийн хөгжилд хувь нэмрээ оруулсан нь илтэд байна.

¹ «БНМАУ-ын түүх», Улсын хэвлэлийн газар, УБ., 1984, 88-р тал

² **Окладников А. П.** «Центрально-Азиатский очаг первобытного искусства (Пещерные росписи Хойт-Цэнхэр-агуй), Западная Монголия. «Наука», Новосибирск, 1972

³ **Д. Дорж** «Дорнод Монголын неолитын булш, бууц», «Шинжлэх ухааны Академийн мэдээ». 1969, N 3, 34—50-р тал.

⁴ **Л. Намсрайнайдан.** Тамсагбулагаас олдсон неолитын үеийн хүний булшны тухай. «Этнографийн судлал», V боть, 6-р дэвтэр, 1977, 122-р тал, Д. Түмэн. Некоторые вопросы палеоантропологического исследования неолита Восточной Монголии, «Труды института общей и экспериментальной биологии АН МНР», 1977, No 12, 159—165-р тал

⁵ **Л. Викторова.** Монголы. Происхождение народа и истории культуры. «Наука», М., 1980, 80-р тал на

⁶ Материалы по истории древних кочевых народов группы дунху, «Наука», М., 1984, 39-р тал

⁷ **Н. Бичурин,** Собрание сведений о народах, в средней Азии в древние времена. М. 1950, 1, 60-р тал

⁸ **Н. Сэр-Оджав.** Эртний түрэгүүд. (VI—VIII зуун) «ШУА-ийн хэвлэл» УБ., 1970

⁹ **Х. Пэрлээ.** Хитан нар тэдний монголчуудтай холбогдох нь. «ШУА-ийн хэвлэл», УБ., 1959

¹⁰ «БНМАУ-ын түүх» Улсын хэвлэлийн газар, УБ., 1964, 169—175-р тал.